


“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын 4 дүгээр хавсралт



БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

1. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйлчилгээний суурь хөлсний хэмжээг 420,000 /дөрвөн зуун хорин мянган/ төгрөг байна.

2. Үйл ажиллагаа эрхлэх ажлын төрлөөс хамаарсан нэмэлт хөлсийг дараах байдлаар тогтоож, тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгалт хийлгэх, нэмэлт ажлын төрөл авах тохиолдолд дараах байдлаар тогтооно.

Д/д	Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал болон хүчин чадлын төрөл	Үйлчилгээний нэмэлт хөлсний хэмжээ /төгрөгөөр/
Нэг. Зураг төсөл боловсруулах чиглэлээр		
1.	Бага төвөгшилтэй	50,000
2.	Дунд төвөгшилтэй	100,000
3.	Өндөр төвөгшилтэй	150,000
4.	Онцгой төвөгшилтэй	200,000
5.	Тухайлсан	250,000
Хоёр. Барилгын ажил гүйцэтгэх чиглэлээр		
1.	Бага төвөгшилтэй	100,000
2.	Дунд төвөгшилтэй	150,000
3.	Өндөр төвөгшилтэй	200,000
4.	Онцгой төвөгшилтэй	300,000
5.	Тухайлсан	350,000
Гурав. Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний чиглэлээр		
1.	Дунд төвөгшилтэй	50,000
2.	Өндөр төвөгшилтэй	100,000
3.	Онцгой төвөгшилтэй	200,000
Дөрөв. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр		
1.	Бага хүчин чадалтай	50,000
2.	Дунд хүчин чадалтай	100,000
3.	Өндөр хүчин чадалтай	150,000

Тайлбар:

1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах "дунд" төвөгшилд 3Т-6, 3Т-10, 3Т-11, 3Т-12-ын заалтууд хамаарна.
2. Барилга байгууламжийн ажил гүйцэтгэх "дунд" төвөгшилд БА-6-ын заалт хамаарна.
3. Барилгын материалын үйлдвэрлэлийн МУ-3.3, 3.4, 3.5 болон 7, 9, 10-ын заалтуудад хамаарах тусгай зөвшөөрөл нь "дунд" хүчин чадалтайд хамаарна.

4. Барилгын материалын үйлдвэрлэлийн 11 дэх заалтад хамаарах эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалын үйлдвэрийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээний суурь хураамж 200,000 төгрөг байна.

----oOo----